

**САНХҮҮ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН НЭГДСЭН ТӨЛӨВЛӨЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ХАРИУЦСАН ШИНЖЭЭЧ ДАВААДУЛАМЫН
МӨНХСОЛОНГЫН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлт ийн хувь
	1	2	3	4	5	6	7
Зорилт 1. “Салбарын санхүү, хөрөнгө оруулалт, төсвийн төлөвлөлтийн нэгдсэн зохицуулалтыг хэрэгжүүлнэ.”							
1.	Арга хэмжээ 1.1. Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны төсвийн төслийг нэгтгэн, боловсруулж, Сангийн яаманд хүргүүлэх	Хүргүүлсэн баримт бичгийн тоо	0	3	Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйл “Төсвийн цагалбар”, 27 дугаар зүйл “Төсвийн төсөлд тавигдах шаардлага”, 31 дүгээр зүйл “Төсвийн ерөнхийлөн захирагчийн жилийн төсвийн төсөл” болон бусад холбогдох хууль эрх зүйн үндэслэлийн дагуу Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээний төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны төсвийн төсөл, 2026-2027 оны төсвийн төсөөллийг боловсруулан Сангийн яам, Улсын Их Хурлын тамгын газар, Үндэсний аудитын газарт 2024 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн 01/25 дугаартай албан бичгээр тус тус хүргүүлсэн. ЦХИХХС-ын багцад 2025 онд 130.3 тэрбум төгрөг батлагдсан. Үүнээс урсгал зардалд 90 тэрбум, хөрөнгө оруулалтын зардалд 40.3 тэрбум төгрөг байна.	03-08	100%
2.	Дэд арга хэмжээ – 1.1.1: Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг нэгтгэн, боловсруулж, Сангийн яам, Эдийн засаг хөгжлийн яаманд хүргүүлэх	Хүргүүлсэн баримт бичгийн тоо	0	1	Цахим хөгжил, харилцаа холбооны сайд бөгөөд Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд урсгал зардалд 117.9 тэрбум, хөрөнгө оруулалтын зардалд 116.6 тэрбум төгрөг, нийт 234.5 тэрбум төгрөгийн саналыг боловсруулж Сангийн яам, Эдийн засаг хөгжлийн яаманд 2024 оны 04 дүгээр сарын 10-	03-04	100%

					ны өдрийн 01/760 дугаартай албан бичгээр тус тус хүргүүлсэн.		
3.	Дэд арга хэмжээ – 1.1.2: Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны төсвийн хязгаарын саналыг нэгтгэн, боловсруулж, Сангийн яаманд хүргүүлэх	Хүргүүлсэн баримт бичгийн тоо	0	1	Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны төсвийн хязгаарын саналд урсгал зардалд 117.9 тэрбум, хөрөнгө оруулалтын зардалд 116.6 тэрбум төгрөг, нийт 234.5 тэрбум төгрөгийн саналыг боловсруулж Сангийн яаманд 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 01/1176 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.	05-06	100%
4.	Дэд арга хэмжээ – 1.1.3: Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны төсвийн төсөл, 2026-2027 оны төсвийн төсөөллийг нэгтгэн, боловсруулж, Сангийн яаманд хүргүүлэх	Хүргүүлсэн баримт бичгийн тоо	0	1	ЦХИХХС-ын харьяа төсөвт 8 байгууллагын 2025 оны төсвийн төсөл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн санал авч нэгтгэн, тооцоолол хийж, Fiscal.B цахим системд арга хэмжээ, эдийн засгийн ангилал тус бүрээр оруулж хуулийн хугацаанд илгээсэн. Сангийн сайд, Улсын Их Хурлын тамгын газар, Үндэсний аудитын газарт 2024 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн 01/25 дугаартай албан бичгээр тус тус хүргүүлсэн.	07-11	100%
5.	Дэд арга хэмжээ – 1.1.4. Төсвийн ерөнхийлөн захирагчийн урсгал төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах	Хүргүүлсэн баримт бичгийн тоо	0	9	ЦХИХХС-ын багцын харьяа төсөвт байгууллагуудын 2024 оны 02-12 дугаар сарын батлагдсан төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах саналыг боловсруулж холбогдох тооцоолол, үндэслэх баримт бичгийн хамтаар 03/315, 03/600, 01/949, 01/1065, 01/11388, 01/418, 01/505, 01/715, 01/1026 дугаартай албан бичгээр Сангийн яаманд тус тус хүргүүлж, батлагдсан төсвийн хуваарьт өөрчлөлт оруулсан.	02-12	100%
6.	Дэд арга хэмжээ – 1.1.5. Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны төсвийн сар, улирлын хуваарийн төслийг нэгтгэн, Сангийн яаманд хүргүүлэх	Хүргүүлсэн баримт бичгийн тоо	0	0	Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6.2-т төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн хуваарийн саналаа жил бүрийн 12 дугаар сарын 25-ны дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх” гэж заасан.	12	-
7.	Дэд арга хэмжээ – 1.1.6. Төсвийн ерөнхийлөн	Төсөвт зохицуулалт	0	0	Сангийн сайдын 2018 оны 134 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам”-ын 2.1, 2.1.4-т	01-12	100%

	захирагчийн 2024 оны төсвийн зохицуулалт болон санхүүжилтэд өөрчлөлт оруулах санал хүргүүлэх	хийсэн тушаалын тоо			заасны дагуу төсөв захирагчийн төсвийн тогтвортой байдлыг хангах, санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх төсөвт зохицуулалт хийх шаардлага үүссэн тул Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2024 оны төсвийн багцад хамаарах зориулалт хооронд нийт 9.9 тэрбум төгрөгийн төсөв зохицуулалт хийх тушаалыг албажуулж, үндэслэх баримт бичиг, тооцооллын хамтаар Сангийн яаманд хүргүүлж төсөв зохицуулалт хийлгэсэн.		
8.	Арга хэмжээ – 1.2: Төсвийн ерөнхийлөн захирагчийн хөрөнгө оруулалтыг төлөвлөх, тайлагнах, гүйцэтгэлийг хянаж, санхүүжилтийн эрх нээлгэх, санхүүжилтийг олгох	Төлөвлөгөө, тайлан, албан бичгийн тоо	0	6	Хөрөнгө оруулалтын ангилалд 2025 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ тус бүрийн саналыг нэгтгэн төсвийн хөрөнгө оруулалтын цахим систем pubinvestment.gov.mn-д нэгтгэн үнэлж, хуулийн хугацаанд илгээсэн. ТЦҮЗГ-т эрх шилжин хэрэгжсэн 3 төсөл, арга хэмжээний 2.1 тэрбум төгрөгийн санхүүжилтийн эрх нээлгэх хүсэлтийн материалыг бүрдүүлж, санхүүжилтийн эрх нээлгэсэн.	01-12	100%
9.	Дэд арга хэмжээ – 1.2.1: Төсвийн ерөнхийлөн захирагчийн хөрөнгө оруулалтыг төлөвлөх	Батлагдсан төлөвлөгөөний тоо	0	1	1. ЦХИХХС-ын 2025 оны хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний саналд нийт 142 тэрбум төгрөгийн 30 төсөл, арга хэмжээг төсвийн хөрөнгө оруулалтын цахим системээр төлөвлөж, ач холбогдол, олон нийтийн санал асуулгын үр дүнгээр эрэмбэлж, цахим системээр хуулийн хугацаанд хүргүүлсэн. МУЗГ-ын 2024 оны 93 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Төсвийн төсөл, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийн талаарх олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулах журам”-д заасны дагуу төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны төсвийн төслийг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны https://mddc.gov.mn/mn/ цахим хуудсанд ил тод байршуулж, олон нийтэд хэлэлцүүлсэн үр дүнг нэгтгэн 2024 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн 01/130 дугаартай албан бичгээр	03-11	100%

					Сангийн яаманд хүргүүлсэн. 2025 онд хөрөнгө оруулалтын 7 төсөл, арга хэмжээнд 40.3 тэрбум төгрөг батлагдсан. Үүнд: шилжих 4 барилга байгууламж 16.5 тэрбум, шинээр хэрэгжих 3 төсөл, арга хэмжээний тоног төхөөрөмж ангилалд 23.8 тэрбум төгрөгийн эх үүсвэр тус тус батлагдсан. 2. 2024 оны 3 төсөл, арга хэмжээний эрх шилжүүлсэн шийдвэр, багц задлах ажлыг улсын төсвийн хөрөнгө оруулалтын publicinvestment цахим системд тухай бүр нь оруулсан.		
10.	Дэд арга хэмжээ – 1.2.2: Төсвийн ерөнхийлөн захирагчийн хөрөнгө оруулалтыг тайлагнах	Тайлангийн тоо	0	6	ЦХХХС-ын багцын 2024 оны 01-11 дүгээр сарын улсын төсвийн хөрөнгө оруулалтын явц, гүйцэтгэл, санхүүжилтийн мэдээг сар бүр гарган Сангийн яамны хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газарт албан бичгээр болон улсын төсвийн хөрөнгө оруулалтын publicinvestment.gov.mn цахим системээр тайлагнаж байна.	01-12	100%
11.	Дэд арга хэмжээ – 1.2.3: Төсвийн ерөнхийлөн захирагчийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийг хянаж, санхүүжилтийн эрх нээлгэх, санхүүжилтийг олгох	Санхүүжилтийн эрх нээлгэсэн албан бичгийн тоо	0	0	Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтад ЦХИХХС-ын багцад батлагдсан Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтад Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын багцад батлагдсан XIX.3.4 Цахим орчны хүүхэд хамгааллын тоног төхөөрөмж /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, XIX.3.2 Хороодын цахим үйлчилгээний тоног төхөөрөмж /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг/, XXV.3.1 “Цахим аймаг” төслийн тоног төхөөрөмж /Дундговь/ төсөл, арга хэмжээний санхүүжилтийн хүсэлтийг Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын дагуу хянан баталгаажуулан, санхүүжилтийн	01-12	100%

					эрх нээлгэх хүсэлтийг Сангийн яаманд хүргүүлж, санхүүжилтийг бүрэн олгосон.		
Зорилт 2. “Төрийн сангийн тооцоо, яамны албан хаагчдын цалин, тэтгэмж, хөрөнгийн хөдөлгөөний бүртгэл хийх, хяналт, зохицуулалтыг хэрэгжүүлэх”							
1.	Арга хэмжээ 2.1. Шилэн дансны цахим системд мэдээлэл оруулах	Оруулсан мэдээний тоо	0	67	Шилэн дансны тухай хуульд заасны дагуу 2024 оны 01-12 дугаар сарын нийт 12 төрлийн мэдээлэл /Сайдын багцын, яамны хөрөнгө оруулалтын мэдээ, гүйцэтгэл, Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан, сар бүрийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт/-ийг шилэн дансны мэдээллийн систем www.shilendans.gov.mn -д хуулийн хугацаанд мэдээлсэн. Хугацаа хоцорсон мэдээлэл байхгүй.	01-12	100%
Зорилт 3. Нэгжийн үйл ажиллагаанд оролцож, удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх, мэдээллээр хангах							
1.	Арга хэмжээ 3.1. Тушаал шийдвэр, цаг үеийн болон бусад асуудлаар удирдлагыг үнэн зөв бодит мэдээллээр хангах, өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх	Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь	0%	100%	1.ЦХИХХС-ын 2024 оны арга хэмжээний төлөвлөгөө, ЦХИХХЯ-ны урсгал төсвийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг газар, нэгжүүдээс санал авч батлуулсан. Гүйцэтгэл, явцын мэдээллийг тухай бүр нь удирдлагад танилцуулсан. 2.Төрийн худалдан авах ажиллагааны tender.gov.mn цахим системийн админ эрхээр: -Харьяа төсөвт байгууллагын худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний өөрчлөлтийг шийдвэрлэх, цахим системээр тайлагнахад хяналт тавих, -Үнэлгээний хорооны нарийн бичгийн эрх нээх, ТББ баталгаажуулах, өөрчлөлтийн хүсэлт шийдвэрлэх, -Цахим дэлгүүрийн худалдан авалтыг зохион байгуулах зэрэг ажлыг хийж гүйцэтгэсэн. 3. Ази, Номхон далайн сансрын хамтын ажиллагааны байгууллага (APSCO)-аас хэрэгжүүлж буй "Газар хөдлөлтийн судалгааны II шат" төслийн хүрээнд 50,000 ам.долларын үнэ бүхий магнетометрийг ШУА-ийн харьяа	01-12	100%

					Одон орон, геофизикийн хүрээлэнд буцалтгүй тусламжаар ирүүлсэн. Сангийн Сайдын 2023 оны А/30 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Хүмүүнлэгийн болон буцалтгүй тусламж, хөнгөлөлттэй зээлээр авсан бараа, ажил, үйлчилгээг гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх үйл ажиллагааг зохицуулах журам"-ын дагуу импортын албан татвараас чөлөөлөх хүсэлтийг гадаадын зээл, тусламжийн санхүүжилтын цахим odamis.mof.gov.mn цахим системээр илгээж Сангийн яамны Татварын бодлогын газраас Гаалийн ерөнхий газарт шилжүүлсэн. 4. Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны салбарын үйл ажиллагааг хэвийн явуулах, зайлшгүй шаардлагатай ажил, үйлчилгээг санхүүжүүлэхэд 2025 оны төсвийн төсөл, 2025-2026 оны төсвийн төсөөлөлд нэмэлтээр санал өгөх шаардлага үүссэн тул Бүгд Найрамдах Франц Улсын "Тайлес Алейна Спейс" компанитай Үндэсний хиймэл дагуул төслийн техникийн урьдчилсан зураг төсөл боловсруулах чиглэлээр хамтран ажиллах тухай харилцан ойлголцлын санамж бичгийн хүрээнд хэрэгжүүлэх ажлын нэмэлт санал, Улсын төсвийн хөрөнгө оруулалтад шинээр нэмэх 2 төсөл, арга хэмжээний саналыг нэгтгэж 2024 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн 01/218 дугаартай албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн.			
ХУУЛЬ ТОГТООМЖООР ХҮЛЭЭСЭН БУСАД ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД								
1.	Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 35.4 дүгээр заалтын хэрэгжилтийг хангах	Баримт бичиг, материалын тоо	0	30	2023 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтын нийт 51 боть материалыг архивын нэгж болгон архивт хүлээлгэн өгөхөд бэлэн болсон.	01-12	100%	
2.	Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын	Мэдүүлгийн тоо	0	1	-2023 оны ХАСХОМ-ыг хуулийн хугацаанд баталгаажуулан ЭБАТ-д хүлээлгэн өгсөн.	02-12	100%	

	зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай болон Авилгын эсрэг хууль тогтоомжийг мөрдөх, хэрэгжилтийг хангах				-Ухаалаг засаг-2 төслийн үнэлгээний хороонд ажиллах хүрээнд ашиг сонирхлын зөрчил үүсээгүй талаар мэдэгдлийг тухай бүр баталгаажуулсан.		
--	--	--	--	--	---	--	--

Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт

Д/д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлт ийн хувь
1.	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 1. ЦХХХЯ-ны Төрийн Нарийн бичгийн даргын А/67, А/71, А/74 дугаартай тушаалаар тус тус байгуулагдсан "Ухаалаг засаг-2 төслийн 2024 оны худалдан авалтын төлөвлөгөө"-нд туссан 20 ажлын 6 үнэлгээний хороонд гишүүнээр ажиллах	Гишүүнээр ажилласан тоо	0	6	"Ухаалаг засаг-2 төслийн 2024 оны худалдан авалтын төлөвлөгөө"-нд туссан "Интернетийн харилцан холболтын төхөөрөмжийг шинэчлэх", "Төрийн цахим үйлчилгээг цахимжуулах", "Монгол улсын төрийн худалдан авах ажиллагааны тухай хуулийн дагуу өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн механизмд дүн шинжилгээ хийх, төрийн худалдан авах ажиллагаанд улсын байцаагчдад дэмжлэг үзүүлэх дотоодын бие даасан зөвлөх", "ТБОНӨХБАҮХТх-ийн шинэчилсэн найруулгад нийцүүлэн журам, заавар боловсруулах болон тус хуулийн талаар сонирхогч талуудын мэдлэг дээшлүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд туслалцаа үзүүлэх дотоодын бие даасан зөвлөх", ТХН-ийн тавилга, тоног төхөөрөмж худалдаж авах, "Ахмад настнуудын цахим ур чадварыг нэмэгдүүлэх туршилтын хөтөлбөрийн	01-06	100%

					Маркетингийн бие даасан зөвлөх", "Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх нийтийн төв байгуулах/тоног төхөөрөмж", "Үндэсний нийтийн түлхүүрийн дэд бүтцийн суурь системийг шинэчлэх" ажлын хэсгийн үнэлгээний хороонд гишүүнээр ажиллаж, ТББ боловсруулах болон үнэлгээг тухай бүр хийж хүргүүлсэн.		
2.	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 2. ЦХХХС-ын багцын 2023 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэлд Үндэсний аудитын газраас гүйцэтгэлийн аудит орж байгаатай холбогдуулан холбогдох мэдээ, мэдээллийг хүргүүлэх	Хүргүүлсэн албан бичгийн тоо	0	1	ЦХХХС-ын багцын 2023 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэлд Үндэсний аудитын газраас гүйцэтгэлийн аудит орж байгаатай холбогдуулан хөрөнгө оруулалтын худалдан авах ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, өмч бүртгэлийн мэдээ, судалгаа, төсөл, арга хэмжээний тус бүрийн мэдээг гарган 2024 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 03-120 дугаартай албан бичгээр Үндэсний аудитын газрын гүйцэтгэл-нийцлийн аудитын газарт хүргүүлсэн. Мөн шаардлагатай бусад судалгаа мэдээллийг нэгжийн даргаар хянуулж Үндэсний аудитын газрын аудитор н.Нямжаргалд цахимаар болон цаасаар тухай бүрт хүргүүлсэн.	01-06	100%
3.	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 3.	Зохион байгуулсан	0	1	Сангийн яамны Хууль, эрх зүйн газраас "Төрийн болон	01-12	100%

	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль шинэчилсэнтэй холбогдуулан сургалт авах	сургалтын тоо			орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулга"-ын сургалтыг 2024 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр зохион байгуулсан. Сургалтад ЦХХХС-ын багцын харьяа байгууллагууд болон ЦХХХЯ-ны нийт 59 албан хаагч хамрагдаж мэдээ, мэдээлэл авсан.		
4.	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 4. Өргөн нэвтрүүлэх хөгжүүлэх сангийн 2024 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг цахим системд нийтлэх	Нийтэлсэн төлөвлөгөө ний тоо	0	1	Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2024 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн А/27 дугаартай тушаалаар батлагдсан "Өргөн нэвтрүүлэг хөгжүүлэх сангийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөө"-г төрийн худалдан авах ажиллагааны цахим систем tender.gov.mn-д шивж, баталгаажуулахаар илгээсэн.	01-12	100%
5.	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 5. Хэлтсийн 7 хоног, сар, улирал, жилийн төлөвлөгөө, тайлан гаргах	Хүргүүлсэн тайлан, төлөвлөгөө ний тоо	0	30	Хэлтсийн 7 хоног, сар, улирлын тайлан, төлөвлөгөөг тухай бүр гаргаж нэгжийн даргаар хянуулж ТЗУГ-т нэгтгүүлсэн.	01-12	100%

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлт ийн хувь
			3	4	5	6	7
1.	Төрийн албан хаагчийн мэргэшүүлэх багц сургалт, богино болон дунд	Суралцсан кредит цаг	0	16 цаг	1. Удирдлагын академийн ахлах түшмэлийн багц	02-06	100%

	хугацааны мэргэшүүлэх багц сургалтад хамрагдах				сургалтад хамрагдаж, 8 кредит цагийн хичээл судалж, гэрчилгээ авсан. 2. Удирдлагын академиас зохион байгуулсан "Төсвийн хөрөнгө оруулалтын шинжилгээ" сургалтад нийт 16 цагийн хичээл судалж, гэрчилгээ авсан.		
2.	Хариуцсан чиг үүргийн хүрээнд холбогдох сургалт хэлэлцүүлэгт хамрагдах	Сургалт, хэлэлцүүлгийн тоо	0	3	1. Сангийн яамнаас зохион байгуулсан "Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлага ба цахим шинэчлэл" чадавх бэхжүүлэх сургалтад хамрагдаж батламж авсан. 2. Нээлттэй нийгэм форум НҮТББ-аас 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдөр зохион байгуулсан "Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төслүүдийн хэрэгжилт, тулгамдаж буй асуудлууд, тэдгээрийг хэрэгжүүлэх арга зам" сэдэвт судалгааны ажил танилцуулах уулзалт, хэлэлцүүлэгт хамрагдаж мэдээ, мэдээлэл авсан. 3. Сангийн яамнаас зохион байгуулсан "Засгийн газрын гадаад зээл, тусламжийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх, зохион байгуулах, хяналт тавих, санхүүжүүлэх, үнэлэх журам"-д орсон өөрчлөлтийг танилцуулах уулзалт-хэлэлцүүлэгт 2024 оны 5	02-06	100%

дугаар сарын 10-ны өдөр хамрагдсан.
--

ТАЙЛАН ГАРГАСАН:

Төрийн захиргааны удирдлагын газрын
Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн
шинжээч
(Албан тушаал)

Д.Мөнхсолонго /  /

(Нэр, гарын үсэг)

..... 2024-12-04

(Огноо)